



Mongolia:  
Enhancing Resource  
Management through  
Institutional Transformation

Олон нийтийн хэлэлцүүлэг товч танилцуулга  
MAY 2019

# Олон нийтийн хэлэлцүүлэг гэж юу вэ?

Хууль, эрх зүйн шинэчлэлт хийх, тусгай зөвшөөрөл олгох, уурхайн гэрээ байгуулах зэрэг шийдвэр гаргахад эрх бүхий яам, агентлагууд, төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, үр ашгийг нэмэгдүүлэх чухал арга хэрэгсэл болдог.

Хэлэлцүүлэгт оролцож буй оролцооны түвшингээс шалтгаалан: мэдээлэх, зөвлөлдөх, оролцуулах зэрэг гурван янзын түвшний олон нийтийн хэлэлцүүлгийн төрөл байдаг.

# Оролцооны түвшингүүд

**Мэдээлэх** нь хууль тогтоомж, шинэ дүрэм журмын өөрчлөлтийг мэдээлэх зэрэг мэдээллээр хангах түвшин. Энэ нь нэг талын үйл явц юм - Олон нийт зөвхөн мэдээлэл хүлээн авах байдлаар оролцоно.

**Зөвлөлдөх** Тухайн шийдвэр нөлөөлөлж болох сонирхлын бүлгүүдийн санал хүсэлтийг сонсох идэвхтэй хэлбэр. Энэхүү харилцаа нь мэдээллийн хоёр талт урсгал. Төрийн шийдвэрийг оновчтой байлгах үүднээс олон нийтийн оролцоог хангах хэлбэр.

**Оролцуулах** шийдвэр гаргах үйл явцад олон нийт, оролцогч талуудын идэвх оролцоог хангах хэлбэр. Эцсийн шийдвэрт хамтдаа хүрч оролцогч талууд зөвлөлдөх зарчмаар үүрэг хариуцлагаа хуваалцах боломжийг олгодог.

## Олон нийтийн хэлэлцүүлэг яагаад чухал вэ?

Олон нийтийн хэлэлцүүлэг нь Засгийн Газар илүү сайн шийдвэр гаргахад мэдээллээр хангахын зэрэгцээ олон нийтэд мэдээлэл өгөх боломжийг олгодог

Мөн ЗГ тухайн асуудлаар дүн шинжилгээ хийх, олон нийтийн хүлээлтийг таниж мэдэх ач холбогдолтой.

Хэлэлцүүлэг нь ил тод байдлыг түвшинг дээшлүүлж, дараах үр дүнг авчирна:

- Талуудад өөр хувилбаруудыг санал болгох боломж бүрдэнэ
- Шийдвэр гаргагчид эсрэг үзэл бодлоо нэгтгэх боломж бүрдэнэ
- Асуудлыг урьдчилан харж тодорхойлох
- Зардал, үр ашгийг тооцох боломж
- Төрийн байгууллагууд хоорондоо хамтарч ажиллах

# Жендэрийн асуудал

Эдийн засгийн тогтвортой хөгжил гэдэг нь хөгжлийн хөтөлбөрүүдээс гадуур орхигддог, эсвэл согтууруулах ундааны хэрэглээ, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүсийн бүлэгт анхаарал хандуулах явдал юм.

УУ-н хөгжлийн төслүүд нь соёл, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчин, эмэгтэйчүүдийн хөгжил, эрүүл мэнд зэрэг салбаруудад чухал нөлөө үзүүлдэг

Үүний нэг чиглэл нь аливаа хэлэлцүүлэг, зөвлөлдөх хорооны уулзалтанд хүйсийн тэнцвэрт байдлыг харгалзах явдал байж болно.

# Хэлэлцүүлэг зохион байгуулах ерөнхий зарчмууд

1. Нөлөөлөлд өртсөн, сонирхож байгаа бүх сонирхогч талыг оролцуулах
2. Аливаа шийдвэрийг гаргахын өмнө хэлэлцэх
3. Оролцогч талуудын оролцооны түвшин, хүссэн үр дүнг тооцоолох
4. Ил тод, тууштай, зохион байгуулалттай, цаг үеэ олсон
5. Үндсэн мэдээлэл нь тодорхой бөгөөд ойлгомжтой байх ёстой
6. Таны асууж буй зүйл бүх оролцогчдод ойлгомжтой (хамрах хүрээ) хамааралтай байх, хүмүүс шийдвэр гаргалтанд оролцооныхоо үр нөлөөг ойлгох
7. Засгийн Газар тэдний оруулсан хувь нэмрийг хэрхэн авч үзсэн талаар буцаан мэдээлэх



---

# Зарчмууд

Хамгийн чухал нь:

Хүйс, арьсны өнгө, нас, боловсролын түвшин, шашны итгэл үнэмшлээс үл хамааран олон нийтийн хэлэлцүүлэг нь бие биенээ харилцан хүндэтгэсэн, ялгаварлан гадуурхахаас ангид, тэгш эрхийн зарчимд тулгуурлан явагдах ёстой.